



**ГАЗРЫН ДОРЙТОЛ, ХӨРСНИЙ БОХИРДОЛД ӨРТСӨН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, ДЭВШИЛТЭТ ШИНЭЛЭГ ТЕХНОЛОГИЙН АРГАЧЛАЛЫН СУДАЛГАА ХИЙЖ, МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУРШИЛТЫГ ХИЙХ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АРГАЧЛАЛЫГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 онь 02 сарын 06 өдөр

Дугаар АЭ/2024-17

Улаанбаатар хот

№	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажил үндэслэл гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"><li>- Газрын тухай хууль;</li><li>- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;</li><li>- Байгалийн ургамлын тухай хууль;</li><li>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;</li><li>- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль;</li><li>- Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр;</li><li>- "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын хүрээнд 2021-2030 хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3.6.10 дахь заалт, зорилт 8.3 дахь хэсэг;</li><li>- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.7.4.6 дахь заалт;</li><li>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.</li></ul>
2.	Ажлын зорилго, шийдвэрлэх асуудал	Энэхүү ажлын зорилго нь доройтол, бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэд шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийж, Монгол улсад нэвтрүүлэх, хэрэгжүүлэх туршилтыг хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааны аргачлалыг боловсруулахад оршино.
3.	Хамрах хүрээ	Газрын нэгдмэл сангийн уул уурхайн газраас бусад ангиллын газарт.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс хойш 6 сарын хугацаанд.
5.	Ажлын иж бүрдэл	<ol style="list-style-type: none"><li>1. Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газарт нөхөн сэргээлт хийх аргачлалын төсөл - 1 баримт бичиг;</li><li>2. Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай жишиг ажлын үнэлгээ - 1 баримт бичиг;</li><li>3. Улсын хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр стратеги төлөвлөгөөний төсөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж - 1 баримт бичиг.</li></ol>
6.	Гүйцэтгэх ажлын үе шат, хэмжээ	<ol style="list-style-type: none"><li>1. Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газарт нөхөн сэргээлт хийх аргачлалын төсөл боловсруулах ажлын хүрээнд;</li></ol>

		<ul style="list-style-type: none"> <li>- Доройтол, бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага болон дэвшилтэт шинэлэг технологийн аргачлалын судалгаа хийх;</li> <li>- Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй газрын нөхөн сэргээлттэй холбоотой журам, заавар, аргачлалуудыг судлах, боловсруулсан аргачлалын төсөлтэй уялдуулах санал, шийдэл гаргах;</li> <li>- Доройтсон газрыг тодорхойлох, газар хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагуудын эрх зүйн орчин, үйл ажиллагааны чиглэлүүдийг судалж, нөхөн сэргээлт хийх шалгуур үзүүлэлтийг тогтоосон байх;</li> <li>- Доройтол, бохирдолд өртсөн газрыг газрын нэгдмэл сангийн ангилал болон газар ашиглалтын зориулалт тус бүрээр нөхөн сэргээх аргачлалуудыг уялдуулан, нэгтгэж аргачлалын төслийг боловсруулсан байх;</li> <li>- Газрын нэгдмэл сангийн ангилал болон доройтол, бохирдлын төрөл тус бүрийг харгалзан үзэж, оновчтой нөхөн сэргээлтийн аргыг тодорхойлж, газар хамгаалах, нөхөн сэргээлт хийх зохицуулалтыг иж бүрэн тусгасан байх;</li> <li>- Боловсруулсан аргачлалын төслийг турших хэрэгжүүлэхэд нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, холбогдох чиг үүргийн байгууллагуудыг хамарсан уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг аргачлалын төсөлд тусгах;</li> <li>- Аргачлалын төслийг ГЗБГЗЗЕГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, газар зохион байгуулалтын орон тооны бус мэргэжлийн зөвлөл, БОАЖЯ-ны холбогдох хурлуудаар хэлэлцүүлж, саналыг тусгаж сайжруулах.</li> </ul> <p>2. Газрын доройтол, хөрсний бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээхэд шаардлагатай жишиг ажлын үнэлгээ тооцох ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Доройтол, бохирдолд өртсөн газрыг нөхөн сэргээх чиглэлээр олон улсын туршлага, дэвшилтэт шинэлэг технологийн төсвийн судалгаа хийх;</li> <li>- Монгол улсад амжилттай хэрэгжүүлсэн газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны төсвийн судалгаа хийх;</li> <li>- Газрын нэгдмэл сангийн ангилал болон газрын хөрсний доройтол бохирдлын төрөл тус бүрээр нөхөн сэргээлт хийхэд шаардагдах төсвийг төслийг тооцоолж, боловсруулсан байх.</li> </ul> <p>3. Улсын хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр стратеги төлөвлөгөөний төсөл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмж боловсруулах ажлын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээлтийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төсөл боловсруулах;</li> <li>- Цаашид авч хэрэгжүүлэх урт, дунд, богино хугацааны арга хэмжээ, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон санал, зөвлөмжийг боловсруулах;</li> <li>- Холбогдох хууль эрх зүйн өөрчлөлтөд оруулах саналыг тусгасан байх.</li> </ul>
--	--	--

7.	Тавигдах шаардлага, ажлын туршлага	Мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээд.
8.	Техникийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан "Хот, тосгон, бусад суурины газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлын аргачилсан заавар";</li> <li>- Байгаль хамгаалал, хөрс шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 3298-90;</li> <li>- Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019;</li> <li>- Газар зүйн мэдээллийн системийн ArcGIS программ хангамжийг ашиглан тоон зургийг боловсруулах;</li> <li>- Ажлын тайланг Arial, 12 фонтоор, мөр хоорондын зай 1.15, хуудасны дээд захаас 20 мм-ээс доошгүй, доод захаас 20 мм-ээс доошгүй, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм байхаар боловсруулна.</li> </ul>
9.	Ажлын хяналт, шалгалт	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагчийн хяналтын зардлыг нийт үнийн дүнгийн 5 (тав) хувиар тооцно.</li> <li>- Захиалагчийн хяналтыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Газрын мониторингийн хэлтсийн холбогдох албан хаагчид хийнэ.</li> <li>- Захиалагч ажил шалгасан акт гаргаж, хяналт тавьж ажиллана.</li> </ul>
10.	Архивт хүлээлгэн өгөх материал	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын архивын хэлтэст дараах хэлбэрээр хүлээлгэн өгнө. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын явцын тайлан – цаасан хэлбэрээр 3 хувь, тоон хэлбэрээр 3 хувь</li> <li>- Ажлын эцсийн тайлан - цаасан хэлбэрээр 3 хувь, тоон хэлбэрээр 3 хувь</li> </ul>
11.	Захиалагч байгууллага	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
12.	Санхүүжилт эх үүсвэр	Урсгал зардал 60,000,000 /Жаран сая/ төгрөг
13.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



А.АМАРСАЙХАН

ГАЗРЫН МОНИТОРИНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ДӨЛ

ГАЗРЫН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ, БОДЛОГО  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН



Р.ОТГОНЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН  
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Т.ОЮУНТӨГС